

ҮЙЛ ЯВДАЛ

АЖЛЫН ХЭСЭГ ХУРАЛДАВ



Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, сэтгэл зүйн судалгаа явуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг хуралдлаа. Тус хурлаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн Батлан хамгаалахын сайдын “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, сэтгэл зүйн судалгаа, дүн шинжилгээ хийх арга хэмжээг зохион байгуулах тухай” тушаалын хэрэгжилтийн байдалтай танилцсан юм.

Ажлын хэсгийг Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар удирдан явуулсан бөгөөд ЗХЖШ-аас авч Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлын хүрээнд хэрэгжүүлж арга хэмжээний талаар ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг танилцууллаа.

Мөн Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбаруудын бие бүрэлдэхүүнд гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэг олгох зорилго бүхий “Хууль хэрэглэх зөв хандлага” сэдэвт ажлын явцын талаар БХЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд мэдээлэл хүргэлээ.

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбаруудад алба хааж буй бие бүрэлдэхүүнээс сэтгэл зүйн тандалт, судалгаа авах, цэрэг дайчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх, судлах, сэтгэл зүйн тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх судалгаа явуулах, сургалтын хөтөлбөр, удирдамж боловсруулах ажлын явцын талаар Монгол Улсын гавьяат багш, чөлөөнд байгаа хурандаа Г.Мягмаржав танилцуулсан юм.

ХҮН АМЬДРАЛЫНХАА 20 ЖИЛИЙГ АЖЛЫН БАЙРАН ДЭЭР ӨНГӨРӨӨДӨГ

Төрийн албаны зөвлөлөөс энэ сарын 12-ны өдөр яам, агентлагуудын Төрийн албаны зөвлөлийн салбарын зөвлөлийн гишүүдийг хамруулсан цахим сургалтыг зохион байгууллаа. Сургалтад ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг тэргүүтэй ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтэс, төрлийн цэргийн командлалуудын Хүний нөөцийн хэлтэс, мэргэжилтнүүд хамрагдсан юм. Сургалтаар “Ковидын дараах төрийн алба”, “Ажлын байрны стрессийг хэрхэн арилгах” зэрэг олон сэдвээр ярилцаж, санал солилцов. Төрийн албаны зөвлөлийнхөн “Цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан төрийн алба дахь дижитал орон зайн тэлэлт огцом нэмэгдэж, цахимжих үйл явц хурдассан. Төрийн албан хаагчдын ажил, амьдралын зохион байгуулалт, цахимаар ажиллах арга барилд чанарын ахиц дэвшил гарлаа. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төрийн албаны тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг найдвартай хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, оновчтой, зөв зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ дэлхийн улс орнуудын төрийн албаны төв байгууллагаас үүссэн онцгой нөхцөлийн үед улс орондоо явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг анхааралтай судалж, мэдлэг мэдээлэл хуваалцах ажлыг тогтмол явуулж ирсэн” хэмээн онцлов.

Энэ үеэр Нийслэлийн Эрүүл мэндийн газраас нэгэн сонирхолтой



лекц тавигдсан нь ажлын байрны орчин ажиллагсдад хэрхэн нөлөөлдөг тухай байв. Ажлын байрны стресс, бухимдалгүй байхад нөлөөлдөг гурван зүйл байдаг нь нэгдүгээрт хувь хүний эрүүл мэнд, хоёрдугаарт, ажлын байрны эрүүл, аюулгүй орчин, гуравдугаарт, удирдлагын арга барил, хандлага, хамт олны уур амьсгал гэнэ. Хүн дунджаар 10,3 жилийг ажлын өрөөндөө, 5 жилийг ширээний ард, 2 жилийг хуралд, өдөрт 1 цаг түгжирдэг гэж үзвэл 2,4 жилийг замын түгжрэлд өнгөрүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, хүн амьдралынхаа 20 жилийг ажлын байран дээрээ өнгөрөөдөг. Тэгэхээр хөдөлмөрлөх цаг хугацааныхаа оргил үеийг ажлын байран дээрээ өнгөрөөж байгаа

ажиллагсдаа халуун, дулаан уур амьсгалтай хамт олон болгож бүрдүүлэхэд удирдлагын арга барил их чухал гэлээ. ДЭМБ-ын гаргасан судалгаагаар 7 хүн тутмын нэг нь ажлын байрны стресс өртдөг байна. Ажлын байрны стресс өртөх өөр нэг шалтгаан нь тэгш бус хуваарилалт, хандлага, ажлын ачаалал гэлээ. Ажил олгогч нар “Энэ их сайн мэргэжилтэн, ажлаа мэддэг” гэж өндөр ачаалалтай ажиллуулсаар байгаад стресс оруулах, эрүүл мэндээр нь хохироулах үзэгдэл байдаг. Тэгэхээр тэгш хуваарилалт гэдэг ажлын байран дээр хамгийн чухал гээд цахим сургалтад оролцогчид нээлттэй ярилцсан юм.

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН СУВИЛАГЧ НАРТ БЭЛЭГ ГАРДУУЛЛАА

Олон улсын “People to people” байгууллагын Монгол дахь салбарын гишүүд “Олон улсын сувилагчдын өдөр”-ийг тохиолдуулан Цэргийн төв эмнэлгийн сувилагч нарт бараа, бүтээгдэхүүн бэлэглэлээ.

Энэ тухай тус байгууллагын тэргүүн Д.Пүрэвсүрэн хэлэхдээ “Манай байгууллага нь БНСУ-ын “People to people” байгууллагатай нягт хамтын ажиллагаатай ажилладаг. Үүний хүрээнд бид “Цар тахлыг ялан дийлэхийн төлөө” аяныг Солонгосын гишүүдтэйгээ хамтран өрнүүлж байна. Тус аянаараа цар тахлын эсрэг, улаан шугамд ажиллаж байгаа Цэргийн төв эмнэлгийн сувилагч нартаа халдвар хамгааллын хувцас, нэг удаагийн маск, гоо сайхны бүтээгдэхүүн зэргийг бэлэглэж байна. Цэргийн төв эмнэлгийн эмч, сувилагч нар нь цар тахал дэгдсэн үеэс эхлэн өргөсөн тангарагтаа үнэнч байж, коронавирусын эсрэг тэмцсээр олон хүний алтан амийг аварч байгаа. Бид тэд нараар маш их бахархаж байна” гэсэн юм.

“People to people” байгууллага нь шашин, улс төрөөс ангид зөвхөн хүний сайн сайхан руу чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ажээ. Тус байгууллагыг анх 1957 онд АНУ-ын ерөнхийлөгч Д.Эйзенхауэр байгуулж байжээ.

УУЛЫН ЯВГАН ЦЭРГИЙН ХАМТАРСАН СУРГАЛТ, ДАДЛАГЫН ТАЛААР ЯРИЛЦЛАА

Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг өчигдөр ХБНГУ-ын Уулын явган цэргийн 23 дугаар бригадын Сургалтын хөдөлгөөнт бүлгийн дарга, дэд хурандаа Ё.Швеглер нарыг хүлээн авч, уулзлаа. Уулзалтаар талууд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Уулын явган цэргийн сургалт”-ын талаар хөндөн ярилцаж, энэ жилийн сургалт, дадлагын онцлог, явагдах цаг хугацаа, хамрагдах бүрэлдэхүүний талаар санал солилцлоо. Дэд хурандаа Ё.Швеглер “Эрхэм дотнын нөхөд болсон Монгол Улсын цэргийн алба хаагчдаа түүхт 100 жилийнх нь ойн баярын мэнд хүргэе. Бидний 2019, 2020 онуудад удирдан явуулсан “Уулын явган цэргийн анхан шатны болон дунд шатны сургалт” нь үр дүнтэй байж, ууланд авирах, буухаас эхлээд уулархаг газар районд байлдааны ажиллагаа явуулах чадварт суралцсан. Бид дараа дараагийн сургалт дадлагуудыг хамтран явуулснаар Монгол Улсын Зэвсэгт хүчний уулын явган цэргийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна” хэмээн уулзалтын үеэр онцолж байсан юм.

Бригадын генерал С.Дашзэвэг “Монгол Улс, ХБНГУ-ын хооронд цэргийн дипломат харилцааны түүх шинэ агуулгаар баяжиж, батлан хамгаалах хамтын ажиллагаа жилээс жилд өргөжин тэлж байгаагийн нэгэн илэрхийлэл нь Зэвсэгт хүчний хамтарсан уулын явган цэргийн сургалт билээ” хэмээгээд Зэвсэгт хүчний 331 дүгээр ангид түшиглэн явагддаг энэхүү сургалт, дадлагын талаар санал солилцлоо.

Мөн Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар ХБНГУ-ын Уулын явган цэргийн 23 дугаар бригадын Сургалтын хөдөлгөөнт бүлгийн дарга, дэд хурандаа Ё.Швеглерийг хүлээн авч уулзаж, хоёр улсын хамтарсан сургалт дадлагын талаар ярилцсан юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчин, ХБНГУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан “Уулын явган цэргийн дунд шатны сургалт” нь өнгөрсөн онд “Уулын явган цэргийн тактикийн ажиллагаа-буудлага”, “Тактикийн ажиллагаа-хадан авиралт” сэдвийн хүрээнд явагдсан юм

“МОНГОЛ ЦЭРГҮҮД ХАМГИЙН ИТГЭЛТЭЙ НӨХӨР БАЙЖ ЧАДДАГ”

ИБНАУ дахь “Умард Атлантын Гэрээний Байгууллага”-ын тэргүүлсэн “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүнд АНУ-ын Аляска мужийн “Үндэсний гвардын хамтын ажиллагааны төлөө” медалийн туузыг гардуулах ёслол энэ сарын 10-ны өдөр боллоо.

Шагнал гардуулах ёслолын үеэр АНУ-ын холбогч офицер ахмад Жесика Меллер “Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчид ямар ч нөхцөлд үүргээ нэр төртэй гүйцэтгэдэг дайчид. Бид хамтран ажиллахад урамтай байдаг. Бидний хамгийн сайн түнш, итгэлтэй нөхөд билээ” хэмээн тодотгож, баяр хүргэсэн юм. Арга хэмжээ халдвар, хамгааллын дэглэмийн хүрээнд явагдлаа.

Энэхүү медалийн тууз нь Монгол Улсын Зэвсэгт хүчин, АНУ-



ын Аляска мужийн Үндэсний гвардын хамтын ажиллагааны хүрээнд хамтран энхийг сахиулах үүрэг

гүйцэтгэсэн хоёр орны цэргийн алба хаагчдад олгогдог шагнал юм.

АРХИНААС ТАТГАЛЗЬЯ



Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Тус Цэргийн штаб Засгийн газрын 2017 оны “Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 46 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын

2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн “Архидан согтуурахтай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” А/83 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу Багануур дүүргийн Засаг даргын тамгын газрын хэлтэс, албадад “Архины хор, нөлөө” сэдвээр мэдээ, мэдээлэл бэлтгэн танилцуулан, “Архинаас татгалзья” нэг сарын аянд нэгдэхийг уриалаад байна. Энэ дагуу нийслэл, дүүргийн цэргийн штабуудад 2021 оны 37 тоот албан бичгээр “Архинаас татгалзья” нэг сарын аянд нэгдэхийг уриалан, цаашид сар бүр 1 дүүрэг аяныг үргэлжлүүлэхээр боллоо.

Мөн нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас зохион байгуулсан “Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа” сэдвээр зохион байгуулсан сургалтад Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицер, ахлагч нар хамрагдан “Ажлын байрны аюулгүй ажиллагаа” 7 хоногийн аяныг зарлаад байна. Тус аяны хүрээнд Цэргийн штабын өрөө тасалгааны хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдлийг үнэлэн, галын аюулгүйн зааварчилгаа, сэрэмжлүүлгийг бэлтгэн байршуулж, ажлын байрны аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.